

**ТӨРӨӨС ОЛГОХ УРАМШУУЛЛААС НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОЛОН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ СУУТГАН ТӨЛӨХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “улаан буудайн” гэсний дараа “, хүнсний ногооны” гэж, “шимтгэлийг” гэсний дараа “тухайн” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Батлут, Б.Бейсен, Ц.Идэрбат, Б.Саранчимэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/

2. Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төрөөс олгох урамшууллаас” гэсний дараа “эрүүл мэндийн болон” гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

3. Төслийн 3 дугаар зүйлийн гарчгийн “, шаардлага” гэснийг хасаж, мөн зүйлийн 3.1 дэх хэсгийн “улаан буудайн” гэсний дараа “, хүнсний ногооны” гэж нэмэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг

4. Төслийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсэг нэмэх:

“3.2. Төрөөс олгох урамшуулал авах эрх үүссэн иргэн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг уг урамшууллаас төлж болно.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

5. Төсөлд дор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл. Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх иргэнд тавигдах шаардлага

4.1. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлээ төрөөс олгох урамшууллаас суутган тооцуулах иргэн дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1,2,3,7 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгоогүй байх;

4.1.2. Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй байх;

4.1.3. Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхийг зөвшөөрч, хүсэлт гаргасан байх.”

Санал гаргасан: Ажлын хэсэг

6.Зарчмын зөрүүтэй саналын 4 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсгийг тус тус хасах.

Санал гаргасан:Ажлын хэсэг

7.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “төв байгууллагаас” гэснийг “төв байгууллага энэ хуулийн 4.1-д заасан журмын дагуу суутган эрүүл мэндийн болон” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан:Ажлын хэсэг

8.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Энэ хуулийг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан:Ажлын хэсэг

НАЙРУУЛГЫН САНАЛ

1.Төслийн гарчгийн, 2 дугаар зүйлийн, 4 дүгээр зүйл, мөн зүйлийн 4.1, 4.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн” гэснийг, “эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

2.Төсөлд шинээр зүйл, хэсэг нэмсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлэх, мөн төслийн нэр томьёо, найруулгыг жигдлэх.

Санал гаргасан:Ажлын хэсэг

Ажлын хэсэг